



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/213

Арвайхээр

Бүтэц, орон тооны дээд хязгаарыг  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.3 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” А/61 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн “Боловсрол, шинжлэх ухааны газрын бүтэц, орон тооны дээд хязгаар”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Байгууллагын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулан батлуулах, хэрэгжилтийг ханган ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Н.Чимэддорж-Ойдов)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн “Боловсрол, шинжлэх ухааны газрын дүрэм, бүтэц орон тооны дээд хязгаар батлах тухай” А/225 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт болох “Боловсрол, шинжлэх ухааны газрын бүтэц орон тооны дээд хязгаар”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0396

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 10/01 дугаар захирамжийн хавсралт



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН БҮТЭЦ  
ОРОН ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР

Боловсрол, шинжлэх ухааны газар		Орон тоо
1	Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга	1
Захиргаа удирдлага, судалгааны хэлтэс		
2	Хэлтсийн дарга (Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл, хүний нөөцийн бодлого, гадаад харилцаа, хамтын ажиллагаа, боловсролын салбарын урсгал төсвийн төлөвлөлт, зохицуулалт, хөрөнгө оруулалт, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ судалгаа, Авлигатай тэмцэх газрын ЭБАТ хариуцах)	1
3	Бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах арга зүйч (Өргөдөл гомдол, дотоод ажил, гүйцэтгэлийн үнэлгээ, тэгш хамран сургалт, салбарын шагнал урамшууллын асуудал хариуцах)	1
4	Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах арга зүйч	1
5	Салбарын хөрөнгө оруулалт, төсвийн гүйцэтгэл хариуцсан ахлах арга зүйч	1
6	Цахим технологи, мэдээллийн сүлжээ, статистик мэдээ хариуцсан ахлах арга зүйч (арга зүйч) (Шинжлэх ухаан технологи, инновац, мэргэжлийн боловсролын асуудал хариуцах)	1
7	Хүүхдийн эрх, хөгжил хамгаалал хариуцсан ахлах арга зүйч (арга зүйч) (Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, дотуур байрны асуудал хариуцах)	1
8	Боловсролын хяналтын улсын байцаагч (Сургалтын орчин, боловсролын бичиг баримт олгох асуудал хариуцах)	1
9	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан ахлах арга зүйч (арга зүйч) (Шим тэжээлийн боловсрол, хүнсний аюулгүй байдал, эрүүл мэнд, орчны эрүүл ахуйн асуудал хариуцах)	1
10	Нягтлан бодогч	1
11	Архив, бичиг хэргийн ажилтан	1
12	Нярав	1
13	Жолооч	1
Сургалт арга зүйн хэлтэс		
14	Хэлтсийн дарга (Сургалтын бодлого, хэрэгжилт, багшийн мэргэжлийн хөгжил, арга зүй, гүйцэтгэлийн үнэлгээ, мэргэжлийн зэрэг, сургалт хөгжлийн шинжилгээ судалгааны асуудал хариуцах)	1
15	Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан ахлах арга зүйч (арга зүйч)	1
16	Бага боловсрол хариуцсан ахлах арга зүйч (арга зүйч)	1
17	Монгол хэл, бичиг, уран зохиолын боловсрол хариуцсан ахлах	1

	арга зүйч (арга зүйч)	
18	Математикийн боловсрол хариуцсан ахлах арга зүйч (арга зүйч) (Гүйцэтгэлийн үнэлгээ, чанарын болон элсэлтийн ерөнхий шалгалт хариуцах)	1
19	Физик, мэдээллийн технологийн боловсрол хариуцсан ахлах арга зүйч (арга зүйч) (Багшийн цахим кампус, байгууллагын мэдээлэл технологийн сүлжээ хариуцах)	1
20	Гадаад хэлний боловсрол хариуцсан ахлах арга зүйч (арга зүйч) (Ахлах ангийн сонгон судлах хичээлийн зохион байгуулалт, хөтөлбөрийн хэрэгжилт, газрын дэргэдэх Багш хөгжлийн төв хариуцах)	1
21	Биеийн тамир, эрүүл мэндийн боловсрол хариуцсан ахлах арга зүйч (арга зүйч) (Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох асуудал хариуцах)	1
22	Дүрслэх урлаг, зураг зүй, технологийн боловсрол хариуцсан ахлах арга зүйч (арга зүйч) (Сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагаа, дүрэмт хувцас хариуцах)	1
23	Нийгмийн ухаан (түүх, газар зүй, нийгэм судлал, иргэний ёс зүй)-ны боловсрол хариуцсан ахлах арга зүйч (арга зүйч) (Сайн хичээлийн технологийн сан, жендерийн асуудал хариуцах)	1
24	Хими, биологийн боловсрол хариуцсан ахлах арга зүйч (арга зүйч) (кабинет, лаборатори, сургалтын тоног төхөөрөмжийн ашиглалт хариуцах)	1
25	Хөгжмийн боловсрол хариуцсан ахлах арга зүйч (арга зүйч) (Сурах бичиг, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцах)	1
	<b>Батлагдсан орон тоо</b>	<b>25</b>